



НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН  
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035  
Утас/Факс: (976-11) 32-71-99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022. 02. 10 № 04/579

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал ирүүлэх тухай

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, хүнд суртлыг бууруулах, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарласан.

“Хотын иргэний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналаа бодлогын баримт бичгүүд болон байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан иргэдийн саналыг тусган 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамж болон төлөвлөгөөний төслийн саналын загварыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт <sup>4</sup> хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Ү.ГАНБОЛД



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2022 оныг "Хотын иргэний жил"  
болгон зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, хүнд суртлыг бууруулах, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарласугай.

2. "Хотын иргэний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Нийслэлийн иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх, дүрэм, стандартыг сурталчлах, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах, эрүүл мэндийг анхаарах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрэхүйц ажлыг санаачлан зохион байгуулж, ажиллахыг нийслэлийн бүх шатны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. "Хотын иргэний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг иргэн, хувийн хэвшлийн байгууллагын саналыг тусган боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

5. Төрийн албыг хувийн ашиг сонирхлоос ангид байлгах, хүнд суртлыг бууруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, нэгдсэн удирдлагаар ханган явц, үр дүнг улирал тутам Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Нийслэлийн Засаг даргын орлогч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Нийслэлийн Ерөнхий архитектор нарт, "Хотын иргэний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг олон нийтэд тогтмол мэдээлж, сурталчилж байхыг Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газар (Г.Хонгорзул)-т тус тус үүрэг болгосугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР

111020000717

Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
01 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/01 дүгээр захирамжийн  
хэвсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга:** Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч
- Гишүүд:** Нийслэлийн Засаг даргын нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч;  
Нийслэлийн Засаг даргын барилга, орон сууц, үйлдвэр, технологийн паркийн асуудал хариуцсан орлогч;  
Нийслэлийн Засаг даргын цахим хөгжил, хууль, эрх зүй, төрийн үйлчилгээний асуудал хариуцсан орлогч;  
Нийслэлийн Засаг даргын авто замын түгжрэлийг бууруулах болон зам, тээврийн асуудал хариуцсан орлогч;  
Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлыг бууруулах асуудал хариуцсан орлогч;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;  
Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;  
Нийслэлийн Ерөнхий архитектор;  
Багануур дүүргийн Засаг дарга;  
Багахангай дүүргийн Засаг дарга;  
Баянгол дүүргийн Засаг дарга;  
Баянзүрх дүүргийн Засаг дарга;  
Налайх дүүргийн Засаг дарга;  
Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;  
Сүхбаатар дүүргийн Засаг дарга;  
Хан-Уул дүүргийн Засаг дарга;  
Чингэлтэй дүүргийн Засаг дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга;  
Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга;

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга;  
Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хяналт, үнэлгээний хэлтсийн дарга;  
Нийслэлийн Боловсролын газрын дарга;  
Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга;  
Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга;  
Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газрын дарга;  
Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга;  
Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга;  
Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга;  
Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;  
Нийслэлийн Сургалт, судалгаа, олон нийттэй харилцах газрын дарга;  
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дарга;  
Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;  
Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга.

Нарийн бичгийн дарга:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

“ХОТЫН ИРГЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАХ САНАЛ

2022 оны 02 дугаар сарын ....

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
НЭГ. ХОТЫН СОЁЛЫГ ТӨЛӨШҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
1.1	Арга хэмжээ			
1.2	Арга хэмжээ			
...				
ХОЁР. ДҮРЭМ СТАНДАРТЫГ СУРТАЛЧЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
ДӨРӨВ. АМЬДРАХ ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
ТАВ. ЗРҮҮЛ МЭНДИЙГ АНХААРАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				
ЗУРГАА. АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД				